



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын I хурал 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд аймгийн Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 15 гишүүд оролцохоос 15 гишүүнтэй 100% ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. БНХАУ-ын ӨМӨЗО-ны хил залгаа Манжуур хотод коронавирусын 2 тохиолдолд илэрсэн талаарх мэдээллийг сонсох,
2. Дорнод аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяад

1. Мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийг ахалж Хавирга, Баянхошуу боомтуудад ажиллуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх,
2. Хавирга, Баянхошуу боомтуудын хяналт шалгалтыг чангатгах, гарах чиглэлийн зорчигчдод санамж, анхааруулга өгч ажиллах,
3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж хүргүүлэх,
4. Гахай, тахианы мах болон жимс, жимсгэнэ, төмс хүнсний ногоог хилээр нэвтрүүлэхгүй байхад хяналт тавих,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаад

1. Иргэдэд санамж, сэрэмжлүүлэг өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах,
2. Бүсийн оношлогоо эмчилгээний төвд болзошгүй тохиолдолд ашиглах өвчтөн тусгаарлах 3 өрөөг бэлэн болгох,
3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд сэрэмжлүүлэг өгөх,
4. Шаардлагатай нэг удаагийн ариутгал халдваргүйжүүлэлтийн хувцас, хэрэгсэл, эм тарианы жагсаалтыг гаргаж танилцуулан холбогдох зардлыг шийдвэрлүүлэх,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
дэд хурандаа Б.Бямбаад.

1. Сүхбаатар аймгийн Бичигтийн боомт дээр онцгойлон анхаарах, тус аймгийн Тагнуулын газар, Цагдаагийн газартай хамтран ажиллах, мэдээ мэдээллийг шуурхай солилцох,

Автотээврийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөрд.

1. Хилийн боомтоор зорчиж байгаа автотээврийн хэрэгслийг хязгаарлах талаар албан бичгийг Улсын Онцгой комисс, Зам тээвэр хөгжлийн яаманд хүргүүлэх,

Гадаадын харъяатын Зүүн бүс дэх газрын
дарга Б.Тамирт

1. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, байгууллага, гадаад иргэдийн судалгааг гаргаж танилцуулах,
2. Хилээр нэвтэрч байгаа гадаад иргэдийн хаягийн бүртгэлийг хүн тус бүрээр гаргах,

Хэрлэн сумын орлогч дарга, Онцгой комиссын
гишүүн О.Пүрэв-Очирт

1. Хэрлэн сумын нутаг дэвсгэрт хяналт шалгалт, тандалт хийх ажлын хэсэг байгуулж ажиллахыг тус тус үүрэг болголоо.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧИГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА